

ОХУ-ЫН ЭДИЙН ЗАСГИЙН БҮС НУТГИЙН БОДЛОГЫН ОНЦЛОГ

*М.Татьяна**

Даяаршил болон бүс нутгийн интеграцчлалын асуудал дэлхий нийтийн анхаарлыг татаж бүх түвшинд хамгийн их яригдсаар ирлээ. Сүүлийн арав гаран жилд дэлхийн улс орнуудын хоорондын улс төр, худалдаа-эдийн засаг, соёлын харилцаа идэвхжсэнээр дэлхийн эдийн засгийн газар зүйн зураг ихээхэн өөрчлөгдсөн билээ.

Монгол Улсын хойд хөрш ОХУ-ын эдийн засгийн бүс нутгийн бодлогыг авч үзэхэд эдийн засгийн бүсчлэл нь түүний салшгүй хэсэг бөгөөд энэ нь улмаар Оросын бүс нутгийн гадаад бодлогыг тодорхойлж өгдөг гэж үздэг юм байна.¹

1996 онд ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин “ОХУ-ын бүс нутгийн бодлогын үндсэн зарчмуудын тухай”² тогтоол баталсан юм. Мөн Бүс нутгийн хөгжлийн сан байгуулж тус сангаас бүсүүдийн нийгэм-эдийн засгийн хөгжлийг дэмжих болон эдийн засгийн чөлөөт бүс байгуулах холбооны хөтөлбөрийг санхүүжүүлж эхэлсэн билээ.

Оросын маш том нутаг дэвсгэрийг холбооны нэгдсэн удирдлаган доор хөгжүүлэх зорилгоор мөн регионуудын хоорондын алсагдмал байдлыг харгалзан тэдгээрийн эрх ашгийн үүднээс ОХУ-ын Ерөнхийлөгчийн 2000 оны 5-р сарын 13-ны өдрийн зарлигаар холбооны 7 тойрог баталсан³ бөгөөд ОХУ-ын Бүс нутгийн хөгжлийн Яам нь⁴ Оросын гүйцэтгэх засаглалын холбооны байгууллага бөгөөд Оросын субъектууд, Умард хязгаар, Арктикийн нийгэм-эдийн засгийн хөгжлийн хууль эрх зүйн талаар төрийн бодлого боловсруулах, ОХУ-ын захиргааны нэгж, нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын хүрээнд Оросын гүйцэтгэх засаглалын холбооны байгууллага, субъектуудын гүйцэтгэх засаглалын байгууллага болон орон нутгийн захиргааны байгууллага хоорондын гүйцэтгэх үүргийг зааглах, мөн барилга, архитектур, хот тохижилт, орон сууц-хот нийтийн аж ахуй, төрийн үндэсний бодлого, үндэстэн хоорондын харилцаа, үндэстний цөөнх, цөөн тоот үндэстнүүдийн эрх ашгийг хамгаалах талаар бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллага билээ.

Тус яам нь түүний харьяа байгууллага болох Барилгын болон орон сууц-хот нийтийн аж ахуйн холбооны агентлагийн үйл ажиллагааг удирддаг. Яам нь үйл ажиллагаандаа Оросын Үндсэн хууль, бусад хууль зүйн акт, холбооны хуулиуд, Оросын Ерөнхийлөгчийн болон Засгийн газрын актууд, Оросын олон улсын гэрээг дагаж мөрддөг.

*Эдийн засгийн бүсчлэл*⁵ нь үйлдвэрлэл, байгалийн баялаг, нийгэм, улс төрийн хүчин зүйлүүдээс хамаарна. Үйлдвэрлэлийн хүчин зүйл нь бүс нутгийн

* М.Татьяна - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

үйлдвэрлэх хүчний зохион байгуулалтын хэлбэр болон аж ахуйн онцлогийг тодорхойлоход голлодог. Газар нутгийн хөдөлмөрийн хуваарь нь бүс нутгийг бий болгоход гол элемент болдог. Энэ нь тус үйл явцын аж ахуйн чиглэл болон тус газруудын хоорондох эдийн засгийн хөгжлийг тодорхойлж өгдөг.

Эдгээр холбооны тойргийг бий болгох гол зорилго нь Орос улсын төвийн нэгдсэн удирдлагыг сэргээх, дотоод байдлыг тогтвортой болгох, аюулгүй байдлыг хангах, тусгаар тогтнолыг хадгалах, Үндсэн хууль бусад төрийн хуулиудыг дээдлэн хүндлэхэд оршино. Эдгээр эдийн засгийн бүсүүдийг бий болгохдоо Оросын олон тооны үндэстэн, захиргааны бусад онцлог дээр биш, харин зөвхөн эдийн засгийн онцлогийг харгалзан хуваасан гэж үздэг.

Бүсчлэлийг бий болгоход нөлөөлсөн чухал хүчин зүйлүүдийн дотор: нэгд, түүхэн үетэй холбоотой, хоёрт, хүний хөдөлмөр, гуравт, үйлдвэрлэх хүчин нь байнга өөрчлөгдөж буй элемент гэж үздэг. Иймээс эдгээр хүчин зүйлүүдээс хамааран бүсчлэл нь өөрчлөгдөж байдаг.⁶

Оросын нутаг дэвсгэр нь макро эдийн засгийн үүднээс Европын хэсгийн макро бүс болон Дорнод хэсгийн макро бүс гэж 2 том бүсэд хуваагддаг.

Европын хэсгийн макро бүсэд Оросын хүн амын 78%, үйлдвэрлэлийн 73%, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний 76% тус тус хамрагддаг.⁷ Гэвч тус бүс нь түүхий эдийн хосмолтой, юуны түрүүнд түлш-эрчим хүчний нөөцөөр дутагддаг.

Харин Дорнод хэсгийн макро бүсэд түүхий эд, байгалийн баялаг төвлөрдөг бөгөөд Оросыг түүхий эд, түлш, бусад материалаар хангадаг. Энд нүүрсний олборлолтын 79%, газрын тосны 69%, байгалийн хийн 92%, өнгөт металлургийн бүтээгдэхүүний 62%-ийг тус тус үйлдвэрлэдэг.⁸ Ихэнхийг нь Оросын Европын бүс, гадаад орнуудад экспортлодог байна.

Макро бүсүүд нь холбооны ач холбогдолтой бөгөөд үндэсний зорилтод хүрэхийн тулд нэгдмэл эдийн засгийн орон зай бий болгох онцгой үүрэг гүйцэтгэдэг. Орос улс нь эдгээр макро бүсүүдээр дамжин субъектуудтэйгээ харилцдаг байна. Төв, Хойт, Баруун-хойд, Ижил мөрөн-Вятын, Төв-Черноземын, Хойт Кавказын, Ижил мөрөн хавийн, Уралын, Баруун Сибирийн, Дорнод Сибирийн, Алс Дорнодын бүсүүд болон Калининградын муж гэсэн нийт 12 эдийн засгийн бүсэд хуваагддаг байна.

Холбооны тойрогууд /ХТ/ нь ерөнхийдөө эдийн засгийн 2 бүсээс бүрддэг. Жишээ нь Төв ХТ – Төв болон Төв-Черноземын бүс, Баруун-Хойд ХТ – Баруун—Хойд, Хойд бүс болон Калининградын муж, Сибирийн ХТ – Дорнод Сибирь болон Баруун Сибирээс /Тюмень муж орохгүйгээр/, Өмнөд ХТ – Хойд Кавказ ордог. Харин Ижил мөрний сав газрын ХТ болон Уралын ХТ – Ижил мөрөн хавийн болон Уралын эдийн засгийн бүсүүдээс ялгаатай бөгөөд Уралын ХТ-т дорнод Уралын мужууд, Тюмень муж болон Баруун Сибирийн районы Ханты-Мансийн болон Ямало-Ненецкийн 2 автономит тойрог, Приволжский ХТ нь Волго-Вятский эдийн

засгийн район, мөн Ижил мөрний сав газрын төвийн болон баруун Уралын субъектуудээс бүрддэг.

Эдгээр холбооны тойргууд нь эдийн засгийн хэр зэрэг хүчтэй төвүүдийг бий болгож чадах эсэх нь одоогоор тодорхой бус үүний зэрэгцээ тойргууд нь зөвхөн зохион байгуулалт, захиргааны болон субъектууд, яам хоорондын асуудал шийддэг түвшинд үлдэж болзошгүй гэсэн асуудал тавигдаж үүнд тодорхой хугацаа хэрэгтэй гэж үздэг юм байна.

Нөгөө талаас, Оросын эдийн засгийн бүс нутгийн бодлогын хэрэгжилт саармаг байдалд тойргуудын нөөц баялаг, ялгаатай тал, холбооны удирдлагын тэгш бус хандлага, субъектуудын удирдлагуудын бодлого нөлөөлдөг гэж яригддаг юм байна.

Мөн Оросын өмнө тулгарч байгаа нэг шинэ асуудал гэвэл ЗХУ задарсны дараа шинээр бий болсон ТУХН-ын орнуудын хилийн дагуу бий болсон *хил орчмын бусууд* /приграничные районы/ гарч ирсэн. Эдгээр нь хамгийн эмзэг эдийн засагтай гэж үздэг бөгөөд үүнд:

1. Зах зээлийн үед ашиггүй болсон үйлдвэрүүд олноор төвлөрч бүтээгдэхүүнийхээ хэрэгчлэгчийн сонирхолыг алдаж хүнд байдалд орсон.

2. Эдийн засгийн төвүүдээс алсагдмал байрлалтай, мөн тээврийн зардал нь 5-10 дахин нэмэгдэж, байдал улам хүндэрсэн.

3. Холбооны төсвөөс татаас /дотаци/ авдаг байсан.

Харин эсрэгээр Москва хот болон Оросын бусад хөгжсөн газрууд зах зээлд хурдан шилжснээр зах зээлийн дэд бүтцийг бий болгон эдийн засгийн гүн хямралд ороогүй юм. Гэхдээ Оросын ихэнх бүсүүд тулгамдсан асуудалтай хэвээр байна.

Үүний дотор буурай хөгжилтэй /слаборазвитые/, эдийн засгийн хямралтай /депрессивные/, экологийн аюултай /экологически опасные/, хил орчмын /приграничные/ гэж хуваагддаг.⁹

Буурай хөгжилтэй бусууд нь угийн хоцрогдмол /традиционно отсталые/ гэж нэрлэгддэг байна. Оросын дундаж түвшингээс доогуур бөгөөд үүнд ихэнх БНУ-ууд ордог – Хойд Кавказын Дагестан, Ингушет, Чечень, мөн Марий Эл, Алтай, Халимаг, Тува, европ хэсгийн зарим мужууд. Эдгээр газрын хүн амын 80 илүү хувь нь ядуурлын доод түвшинд амьдардаг.

Эдийн засгийн хямралтай бусуудийн үйлдвэрлэл нь уналтад орсон бөгөөд Зөвлөлтийн үед зэвсгийн болон машин үйлдвэрлэлийн чиглэлээр улсын тусгай захиалгаар ажилладаг байсанаа захиалгагүй болсоноор эдийн засгийн гүн хямралд орсон. Хуучин Зөвлөлтийн үед хүчтэй үйлдвэрийн төвүүд байсан Баруун-Хойд, Төв, Ижил мөрөн хавийн, Урал, Баруун Сибирийн, Дорнод Сибирийн бүсүүд багтана.

Экологийн аюултай бусууд нь байгалийн гамшигт өртсөн Мурманск муж, Поволжье, Урал, Кузбасс, Каспийн тэнгисийн ойр хавийн бүсүүд ордог.

Геополитикийн үүднээс *хил орчмын бүсүүдэд* зөвхөн эдийн засгийг сайжруулахаас гадна хил, гаалийн дэд бүгэц бий болгох хэрэгтэй гэж үздэг.

Үүний зэрэгцээ Орос *дезинтеграцлал* буюу интеграцлалын эсрэг үйл явц ажиглагддаг: бүсүүдийн бие даасан байдал, тэдгээрийн хоорондын харилцаа, холбоо сулрах, мөн тус улсын бүрэлдэхүүнээс гарч, өөр улсын бүрэлдэхүүнд орох хандлага нөлөөлдөг – Приморье, Чечен, Татарстан г.м.¹⁰

Харин интеграцлалын жишээ бага байна гэж яригддаг /жишээ нь: ОХУ + Беларусь/. Үүнд улс төрийн хүчин зүйл биш, нэгдмэл зах зээлтэй болох сонирхол давамгайлж, уул интеграцийг төр нь дэмжсэнээр бүс нутгийн бодлогод ашигтай үздэг юм.

Холбооны улсын хувьд Орос нь эдийн засгаа хөгжүүлэхийн тулд бүс нутгийн регионализацлал болон интеграцлал хоёрыг зэрэг явуулах зүйтэй гэж үздэг байна.

Регионализацлалын гол зорилго нь Оросын хөрөнгө оруулалт, санхүүгийн бодлогод бүсүүдийн онцлогийг харгалзан, зарим өөрчлөлтийг бүс нутгийн түвшинд шийдвэрлэх /орон сууц-хот нийтийн аж ахуйн/, хөгжлийн тусгай хөтөлбөр боловсруулахад оршино.

Эдийн засгийн интеграцийн хувьд:

- интеграцлалын системийг тогтворжуулах /зам тээвэр, харилцаа, холбоо, эрчим хүч, усны систем/,
- бүх субъектуудын хоорондын харилцааны механизмыг боловсронгуй болгох,
- эдийн засгийн нэгдсэн гадаад бодлого баримтлах, бүсүүдэд гадаадын зах зээл дээр гарах тэгш нөхцөл бий болгох.

Мөн регионализац болон интеграцлалын хандлагууд хоорондоо зөрчилтэй бөгөөд үүний үр дүнд цаашид регионализац нь бүс нутгийн салан тусгаарлах /сепаратизм/ хандлага болж хувирч магадгүй гэсэн болгоомжлол байдаг юм байна. Төвөөс бүсүүдийн эдийн засгийн биеэ даасан байдлыг хязгаарлах нь тэдгээрт сепаратизмын үндсийг бий болгож байдлыг цаашид улам хурдасгах аюултай гэж үздэг байна. Ийм байдал нь Оросын үндэсний аюулгүй байдалд шинэ асуудал гарган ирж болзошгүй.¹¹

Орос улс эдийн засгийн асар их ялгаатай бүсүүдийнхээ хөгжлийг тэгшлэх гэсэн байр суурь баримталдаг байсан бол одоо АНУ, Японы жишгээр тэдгээрийн *туйлчилсан хөгжил*¹² тулгуурласан. Хөгжингүй орнуудын бүсүүд нь, жишээлбэл, АНУ-ын Калифорни муж, Германы Бавари нь дэлхийн түвшинд өрсөлдөгч бөгөөд тэдгээрийн эдийн засгийн чадавхийг том орнуудтай зэрэгцүүлж болно. 1950-аад оноос хойш Япон улс эдийн засгийн бүс нутгийн бодлого баримталж технополисуудыг байгуулсны үр дүнд гайхалтай хөгжилд хүрсэн билээ. Мөн Калифорни мужийн Силиконы хөндий нь 1950-иад онд байгуулагдаж улсынхаа дэвшилд хүчтэй нөлөө үзүүлсээр байгаа юм.

Иймээс “*донор-бус*” болон эдийн засгийн хямралтай бусууд¹³ гэж байдаг. “*Донор-бус*” нь улсын төсөвт ихээхэн орлого оруулдаг, харин хямралтай бусууд нь улсаас авсан татаасаас доод хэмжээнд орлого оруулдаг байна.

Оросын эдийн засгийн хөгжил нь цаг үе, орон зайд ижил бус бөгөөд хэдхэн бүсүүдэд төвлөрдөг байна. Эдгээрээс Москва, Санкт-Петербург хоёр нь дэлхийн түвшинд өрсөлдөж буй бөгөөд Орос улсын хэмжээнд томд орох төвүүдэд Владивосток, Хабаровск, Красноярск, Новосибирск, Челябинск, Ростов-на-Дону, Доод Новгород, Самара хотууд орж, холбооны-хил орчмын төвүүд – Өмнөд-Сахалинск, Мурманск, холбооны хоорондын – Эрхүү, Оренбург хотууд ордог байна.

Бүсүүдээр авч үзвэл, эдийн засгийн чадавхиар буюу БНБ /Бүсийн нийт бүтээгдэхүүний үзүүлэлт/-ний хувьд БН Якут /Саха/ Улс нь 1-р байр, Ханты-Мансийн автономит тойрог /хүн амын тоо нь 1 сая 433 мянган хүн/ нь 2-р байр эзэлдэг байна. Мөн Ямало-Ненецкийн автономит тойрог нь дэлхийн түвшинд байгалийн хийн томоохон үйлдвэрлэгчийн нэг бөгөөд 1 хүнд ногдох БНБ-ний үзүүлэлтээрээ Ханты-Мансийн тойрогтой адил юм байна. Эдгээр хоёр тойрог нь Тюмень мужид ордог бөгөөд иймээс тус муж нь Оросын эдийн засгийн томоохон бүсийн тоонд ордог юм.¹⁴ Тюмени мужийг Баруун Сибирийн бүрэлдэхүүнээс 2000 онд гаргаж Уралын тойрогт оруулсан.

Харин үүний эсрэг хил орчмын бүсүүдийн 1 хүнд ногдох БНБ-ний хувиар холбооны дундаж үзүүлэлтээс доогуур байдаг.

Оросын хил орчмын хамтын ажиллагаа нь *Европын болон Хятадын буюу Азийн, хуучин социалист орнуудтай хамтын ажиллагааны хэлбэр /ГУХН-ын орнууд/* гэж 3 хуваагддаг байна.

Хил орчмын Европын хамтын ажиллагааны хэлбэрт Балти, Баренцевийн тэнгисийн болон Евроарктикийн орнууд ордогдоос Калининградын муж онцгой байр суурь эзэлдэг байна. Учир нь тус муж замын зангилаа, далайд гарцтай, мөн 27 км-ийн зайд 1 хилийн боомт байрлаж нээлттэй бүсийн гаалийн тусгай дэглэмтэй.¹⁵ Иймээс түүхий эд, материал, сэлбэгийн импорт нь гаалийн онцгой татвараас чөлөөлөгдөж Оросын бусад газруудын хэрэгцээг хангадаг байна. Мөн энд BMW, KIA маркийн машин угсарч, Оросын дотоодын үйлдвэрийн зурагтын 1/3, тоос сорогчийн 1/7 нь энд үйлдвэрлэгддэг, тавилгын 60 гаруй, мах боловсруулах 150 гаруй үйлдвэрийн ихэнх нь Литва, Польшийн хөрөнгө оруулалттай байна. Тус муж Оросын дотоодын үйлдвэрийн махан консервын 1/5 нь үйлдвэрлэж Оростоо 1-р байр эзэлдэг.¹⁶

Оросын Европын хэсгийн баруун хилийн хамтын ажиллагаа арай илүү хөгжиж байгаа нь Орос, Европын Холбооны харилцаа өндөр түвшинд гарсантай холбоотой. Нөгөө талаас, хэрэв ирээдүйд ЕХ-той хилийн либералчилсан дэглэмтэй болсон нөхцөлд хууль бус миграци, контрбандаас

сэргийлэх үүднээс Оросын өмнөд, дорнод хилийн дэглэмийг чангаруулах шаардлага заавал гарч ирнэ гэж үздэг.

Хил орчмын Хятадын буюу Азийн хамтын ажиллагааны хэлбэрт Хятад, Монголтой хил залгаа Оросын 8 субъект орж, улсын хилийн хуурай газрын 34, 8 хувийг эзэлдэг байна. Эдгээр субъектын хилийн худалдаа нь Орос-Хятад, Орос-Монголын худалдаа-эдийн засгийн эргэлтэнд ихээхэн байр эзэлдэг. Гэвч хилийн худалдаа Хятадын талд илүү ашигтайгаар явсаар ирсэн гэж Оросын тал үздэг байна.¹⁷

1997 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Бээжин хотноо “ОХУ-ын холбооны субъектуудын захиргаа /засгийн газар/ болон БНХАУ-ын орон нутгийн засгийн газар хоорондын хамтын ажиллагааны зарчмын тухай Хэлэлцээр”-т¹⁸ Оросын талаас Засгийн газрын орлогч дарга Б.Немцов, Хятадын талаас Төрийн Зөвлөлийн орлогч дарга Ли Ланьцин нар гарын үсэг зуржээ. Үүний үр дүнд 1998 оны 1 дүгээр сард Орос-Хятадын хил орчмын болон бүс нутаг хоорондын худалдаа—эдийн засгийн хамтын ажиллагааны зохицуулах зөвлөл байгуулагдаж одоогийн байдлаар 9 удаа хуралдаад байна. 9-р хурал нь Оросын Алтайн хязгаарын Белокуриха хотод болж, дараагийн 10-р хуралдаан нь Хятадын Урумчи хотод 2008 оны 6-7 дугаар сард болох юм байна.¹⁹

Орос улс нь Хятад, Монгол хоёрын хөгжил буурай бүсүүдтэй хиллэдэг учир хилийн худалдааг идэвхжүүлэх нь эдгээр субъектуудын нийгэм-эдийн засгийн хөгжлийг хурдасгах чухал хүчин зүйл гэж үздэг. Хятад улс нэн хэрэгцээтэй түүхий эд, материал импортлож, гаалийн таатай нөхцөл бүрдүүлдэг. Жишээ нь, 1999 онд гуалин мод, банз импортлох гаалийн татварыг тэглэж, импортлогч нь зөвхөн НӨТ, гаалийн хураамж, сертификатын үнэ, улсын болон орон нутгийн татвар, нийт 1 куб.метрт ногдох 8 ам.долларын төлбөр төлдөг байна. Иймээс Оросын модны экспорт тус хугацаанд 13, 9 хувиас 48-50 хувь болж өсчээ.²⁰

Гэвч сүүлийн жилүүдэд БНХАУ нь ДХБ-ын гишүүн болсноор гаалийн нэгдсэн тарифт шилжиж, мөн хилийн худалдаандаа татварын 50 хувийн хөнгөлөлт үзүүлэхээ больж, хилийн худалдаа өмнөх үетэй харьцуулбал Хятадын талд ашиг багатай болсон.

Иймээс Хятад улс санхүүгийн салбарт илүү анхаарлаа тавьж эхэлжээ. 2003 оны намар БНХАУ-ын Ардын банк Оросын Центробанктай хил орчмын бүсүүдэд худалдааны тооцоог үндэсний валют болох юань, рублиэр хийх тухай тохиролцоонд хүрч 2005 оны 1 дүгээр сараас эхлэн Орос, Хятадын хил орчмын банкууд хоорондоо үндэсний валютаар тооцоо хийж эхэлсэн.²¹ Оросын талаас БН Алтай Улс, Приморский болон Хабаровскийн хязгаарууд, Амур, Чита мужууд, Еврейн автономит муж, Хятадын талаас – Хармөрөн муж, Өвөр-Монгол, Синызьян-Уйгурын өөртөө засах орнууд, Жилинь муж ордог. Өмнө нь санхүүгийн тооцоог америк доллараар хийж

2004 онд Орос, Хятадын худалдааны эргэлт нь 22 тэрбум ам.долларт хүрсэн байна. Харин үндэсний валютын тооцоонд шилжихээс өмнө 2003 оноос эхлэн Амур мужийн Благовешенск хот, Хармөрөн мужийн Хэйхэ хотын санхүүгийн байгууллагууд хоорондоо үндэсний валютаар тооцоо хийж үзсэн байна. Үүний үр дүнд, Хятадын талын мэдээлснээр, Хармөрөн мужийн экспорт 2003 онд өмнөх оньхтой харьцуулбал 21,5 хувиар өссөн.²²

Мөн Орос, Хятад улс хоёр талын хил орчмын бүсүүдэд харилцан хөрөнгө оруулалт хийж, Хармөрөн мужид Оросын бизнесмэнүүд хөрөнгө ихээр оруулах болж Оросын талаас Хармөрөн мужид хийсэн хөрөнгө оруулалтын хэмжээ Хятадын талаас Алс Дорнодод хийсэн нийт хэмжээнээс 4 дахин илүү юм байна.²³

Үүний зэрэгцээ, Алс Дорнодын эдийн засгийн эргэлтийг авч үзвэл, хөрш орнуудтайгаа 18 хувь, Оросын бусад бүстэй 4 хувь, бусад 78 хувь нь тус бүсийн эдийн засгийн дотоодын хамтын ажиллагаа юм. Алс Дорнод нь Азийн эдийн засгийн орон зайд илүү оролцож байгаа нь тодорхой бөгөөд Оросын эдийн засагт оролцоо маш бага байгааг харуулж байна.

Нөгөө талаас, Оросын БН Алтай Улс, Алтайн хязгаар нь Хятадын Синьцзян-Уйгурын өөртөө засах оронтой хил орчмын хамтын ажиллагааг 8 жилийн турш хөгжүүлсээр ирсэн. СУӨЗО-ы хувьд Орос улс нь Казахстаны дараа ордог худалдааны томоохон түнш юм. Энэ бүсийн хамтын ажиллагааны онцлог гэвэл, 2003 оны 9 дүгээр сард баталсан ШХАБ-ын орнуудын олон талт худалдаа-эдийн засгийн хамтын ажиллагааны 2020 он хүртэлх хөтөлбөр, 2004 оны 9 дүгээр сард Бишкек хотноо болсон ШХАБ-ын гишүүн-орнуудын Засгийн газрын тэргүүнүүдийн уулзалтан дээр тус хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталсан байна.²⁴ Үүний дотор 100 гаруй чиглэлээр тусгай төсөл боловсруулж, хэрэгжүүлэх механизмыг тодорхойлсон. Үүнд гол чиглэл нь эрчим хүч, зам тээвэр, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, усны аж ахуй, байгаль хамгаалах салбарууд бөгөөд энэ нь Төв Азийн газрын тос, хийн орд газруудыг хамтран ашиглах ихээхэн ашиг сонирхол аль аль талд байгааг харуулж байна. Мөн тус газарт Эдийн засгийн чөлөөт бүс байгуулж, Новосибирск-Урумчи гэсэн чиглэлийн авто зам БН Алтай Улсаар дамжих болно.²⁵

Хил орчмын бүсүүдийн эдийн засгийн буурай байдал нь Оросын эдийн засгийн тогтвортой байдалд саад болж, дэлхийн эдийн засгийн зах зээл дээр өрсөлдөх чадварыг багасгах хүчин зүйл гэж Оросын тал үзэж байна.

Гэвч хил орчмын бүсүүдийн хөгжилд Орос улс ихээхэн анхаарал тавих боллоо. Учир нь хил орчмын болон хөгжил буурай бүсүүдэд ЭЗЧБ байгуулах нь эдгээрийн *хөгжлийн туйл* болно гэж үздэг.

Аялал жуулчлал, нөхөн сэргээх эдийн засгийн онцгой 7 бүс байгуулах тухай Холбооны хууль батлагдаж үнд Эрхүү муж, БН Алтай Улс, БН Буриад Улс, Алтай, Краснодар, Ставрополийн хязгаар, Калининградын муж орсон.²⁶

Үүнээс харахад, нээлтэй 7 бүсээс 4 нь Монголтой хил залгаа, хамтын ажиллагааны олон жилийн туршлагатай субъект бөгөөд Монголын хувьд бүс нутгийн хөгжлийн шинэ нэн таатай нөхцөл нээгдэж байна хэлж болно.

Аялал жуулчлал, нөхөн сэргээх эдийн засгийн онцгой бүсүүд нь: Эрхүү мужид Большое Голоустное тосгон, Буриадад “Байгал” бүс нь Байгал нуурын эрэгт, Алтайн хязгаарт “**Бирюзовая Катунь**” бүс нь Алтайн районы Катунь голын зүүн эрэг дээр бөгөөд Горный Алтайн Майминскийн болон Чемальский районд тус тус байгуулагдах болно.

Эдгээр бүсүүдэд орон нутгийн онцлогийг харгалзан аялал жуулчлал, уулын цанын спорт, танин мэдэхүйн, адал явдлын аялал жуулчлал, жилийн 4 улирлын амралтын болон нөхөн сэргээх, экотуризм, SPA үйлчилгээг олон улсын өндөр түвшинд үзүүлж жилд 1 сая орчим жуулчид хүлээн авах боломжтой болно. Иймээс олон улсын түвшин өндөр зэрэглэлийн зочид буудлууд, мөн “хаус” хэлбэрийн буудлууд шинээр барих төлөвлөгөө гаргасан. Энд ажлын байр шинээр бий болгож, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, орон нутгийн байгалийн баялаг ашиглах шинэ боломж нээх, бүсүүдийн эдийн засаг дээшилснээр хүн амын амьжиргааны түвшин, чанарыг дээшлүүлэх, тогтвортой хөгжлийг хурдасгах болно.

Дүгнэлт

Монгол Улстай хил залгаа Оросын субъектууд нь тус улсын макро эдийн засгийн бодлогын үр дүнд эдийн засгийн чадавхи сул бөгөөд нийт 4 ангиллын гуравт нь багтах *хөгжил нэн буурай буюуугийн хоцрогдмол байдалтай, эдийн засгийн хямралтай, хил орчмын* гэж нэрлэгддэг байна. Харин Оросын *экологийн хямралтай* ангилалд багтдаг бүсүүд Монголтой хил залгадаггүй.

Нөгөө талаас, эдгээр субъектуудад ЭЗОБ байгуулагдаж олон улсын аялал жуулчлалын бизнесийн таатай нөхцөл үүсч, Байгал нуур, Хөвсгөл нуурыг холбосон аялал жуулчлалын хамтарсан төсөлд Монголын тал өргөнөөр оролцох боломжтой. Мөн Оросын жишгээр Хөвсгөл нуур болон бусад газруудад *хөгжлийн туйл* болох өөрийн ЭЗОБ нээх боломж гарч байна. Үүнд Монголын олон улсын аялал жуулчлалын салбарын олон жилийн туршлага, хөрш зэргэлдээ Оросын эдийн засгийн онцгой бүсүүдийг хөгжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулах нь гарцаагүй. Нөгөө талаас, Монголд аялал жуулчлалын кластерын туршлага судлах хэрэгтэй.

Үүнээс гадна Калининград мужийн жишээгээр Эрхүү, Буриад, Алтай, Алтайн хязгаарын нутаг дэвсгэр дээр мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрүүдийг байгуулах, Монголын ноос, ноосон бүтээгдэхүүний үйлдвэр, ногооны аж ахуй, хөдөө аж ахуй болон бүхий л салбарт хамтран ажиллах боломж нээгдэж байна.

Монгол Улсын хувьд, хөрш орнуудын эдийн засгийн бүс нутгийн бодлого нь түүний эдийн засгийн хөгжилд нөлөө үзүүлсээр ирлээ. Иймээс

Монголын хөгжлийн туйлууд /жишээлбэл, Оросын туршлагаар чөлөөт худалдааны, үйлдвэрлэлийн, аялал жуулчлалын, үйлчилгээний, “технополис” буюу техник-технологийн ЭЗОБ-үүд²⁷/-ыг тодорхойлон хэрэгжүүлэх шаардлага урган гарч байна.

Ашигласан материал:

1. Экономическая география России. Под общей редакцией акад.В.И.Видяпина, д.э.н., проф.М.В.Степанова. М.: ИНФРА-М. 2007. 277-р тал.
2. <http://www.bestpravo.ru/fed1996/data04/tex17860.htm> Указ президента РФ от 03.06.96 n 803 об основных положениях региональной политики в Российской Федерации (по состоянию на 20 октября 2006 года).
3. Экономическая география России. Под общей редакцией акад.В.И.Видяпина, д.э.н., проф.М.В.Степанова. М.: ИНФРА-М. 2007. 284-р тал.
4. Указ Президента РФ №1168 от 13 сентября 2004 г. “О Министерстве регионального развития Российской Федерации”. /в ред. Указа Президента РФ от 24.09.2007 №1274/
5. Экономическое районирование. Экономическая география России. Под общей редакцией акад.В.И.Видяпина, д.э.н., проф.М.В.Степанова. М.: ИНФРА-М. 2007. 277-р тал.
6. Мөн тэнд. 278 –р тал.
7. Мөн тэнд. 278–р тал.
8. Мөн тэнд. 278-р тал.
9. Мөн тэнд. 283–284-р тал.
10. Мөн тэнд. 286-р тал.
11. Мөн тэнд. 286-р тал.
12. *Поляризованное развитие*. Регионоведение. В.А. Дергачев, Л.Б.Вардомский. М.: ЮНИТИ-ДАНА, 2004. 511-р тал.
13. Мөн тэнд. 13-р тал.
14. Мөн тэнд. 270-р тал.
15. http://www.rosuez.ru/oez/oez_types/kaliningrad_oez/ Ф «Об Особой экономической зоне в Калининградской области и о внесении изменений в некоторые законодательные акты Российской Федерации».
16. Регионоведение. В.А. Дергачев, Л.Б.Вардомский. М.: ЮНИТИ-ДАНА, 2004. 348-р тал.
17. Мөн тэнд. 356-р тал.
18. <http://cfo.allbusiness.ru/BPravo/DocumShow.asp?DocumID=54043> Соглашение между правительством Российской Федерации и

- правительством Китайской Народной Республики о принципах сотрудничества между администрациями правительствами) субъектов Российской Федерации и местными правительствами китайской народной республики. соглашение. правительство РФ. 10 ноября 1997 г. (РГ 97-47)
19. <http://www.altairregion22.ru/rus/gov/administration/stuct/dved/300507/050607/> Официальный сайт Алтайского края. Итоговый пресс-релиз. Российско-Китайский координационный Совет по межрегиональному и приграничному торгово-экономическому сотрудничеству. (30-31 мая 2007 г., г. Белокураха)
 20. Регионоведение. В.А. Дергачев, Л.Б.Вардомский. М.: ЮНИТИ-ДАНА, 2004. 357-р тал.
 21. http://www.invest-sale.ru/index.php?action=rbc_comments&id=51658 Отдел экономики. Светлана Барсукова. Р.
 22. Мөн тэнд. Дальнешторгбанк-ны зөвлөлийн дарга Антон Маслий “Амурская правда” сонинд өгсөн ярилцлагаас.
 23. Регионоведение. В.А. Дергачев, Л.Б.Вардомский. М.: ЮНИТИ-ДАНА, 2004. 359-р тал.
 24. <http://www.mid.ru/ns-rasia.nsf/3a0108443c964002432569e7004199c0/7df6f268368ef31e43256b7d004d8985?OpenDocument> Деятельность Шанхайской организации сотрудничества (2001-нач.2005).
 25. <http://www.infoshos.ru/?idn=13> Шанхайская организация сотрудничества: новая структура для гармоничного, справедливого и безопасного мира.
 26. <http://www.rian.ru/economy/20061206/56552557.html> В России создадут 7 туристско-рекреационных особых экономических зон 06/ 12/ 2006
 27. Орост 2005 оноос үйлдвэрлэлийн чиглэлээр онцгой 2 бүс БН Татарстан Улс, Липецк хотод нээгдэж, “технополис” буюу техник-технологийн онцгой 4 бүс Москва /Зеленоград/, Санкт-Петербург, Дубна, Томск хотуудад тус тус нээгдсэн юм.